

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн газар

2024 оны эхний хагас жил

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтын явц	Өөрийн үнэлгээ	Дээд шатны байгууллын үнэлгээ	Үнэлгээний тайлбар
МУ-ын хууль							
1	1	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2016-12-22 Дугаар 2017.02.01	19.1.2.. Хамтарсан багийг нэгдсэн удирдлагаар хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Эрүүл мэндийн байгууллагууд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах хамтарсан багийн үйл ажиллагаанд тогтмол оролцдог	100%	100%	
2	2	Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01	55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.	Сүхбаатар аймгийн төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хүрээнд АЗД мөрийн хөтөлбөрт тусгагдсаны дагуу салбартаа манлайлан ажиллаж буй шилдэг эмч, сувилагч, ажилтан, баг гэсэн номинацаар шалгаруулж 20 сая төгрөгийн урамшуулал олгосон. Улсын төсвийн санхүүжилтээр 2024 онд : Дээшлүүлэх сургалтад Их эмч - 5, Лаборант -1, Сувилагч - 1, Туслах сувилагч - 1 тус тус суралцаж байна. Хавсралт : 4 зураг	70%	70%	

3	3	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 2021-12-17 Дугаар 2022.05.01	8.2.6. үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт;	Эрүүл мэндийн газар нь Монгол улсын үндсэн хууль, бусад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль, засгийн газрын тогтоол зэрэг эрх зүйн актуудыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.	100%	100%	
	4		8.2.8. өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ;	2024 оны 2 дугаар улирлын байдлаар 4 өргөдөл гомдол, ирснээс 50%-ийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн. 1 гомдлын хуулийн хугацааг сунгасан. Үүнээс: - Эмч, эмнэлгийн мэргэжилтний харилцаа хандлагатай холбоотой 2/50%, Иргэний эрүүл аюулгүй орчинд амьдрахтай холбоотой - 2/50%. Өргөдөл, гомдлын 1 дүгээр улирлын мэдээг байгууллагын вэб сайтад байршуулсан. Хавсралт : 1 файл	70%	70%	
	5		8.2.9. хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл;	Эрүүл мэндийн салбарын өвчлөл, эндэгдлийн мэдээг сар, улирал, жилийн эцсийн тайланг цахим систем ашиглан цаг хугацаанд нь гаргаж, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн цахим хуудсанд эргэн мэдээлэл, ном болгон тавигдаж байна. Эрүүл мэндийн сайдын 2019 оны 611 дугаар тушаалын дагуу АНЭ, сум дундын эмнэлэг, өрх, сумын эрүүл мэндийн төвүүд Hinfo-v3 , ЭМД-Health.gov.mn цахим мэдээллийн нэгдсэн программыг ашиглаж байна.	100%	100%	
	6		8.5.2. тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх	Тусгай зөвшөөрлийн комисс 2024 оны 2 дугаар улирлын байдлаар 6 удаа хуралдаж 14 байгууллагын хугацааг сунгаж, 2 байгууллагад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгож, шинээр зөвшөөрөл хүссэн 4 байгууллагад шинжээч томилсон байна. Мөн ЭМС-н 2023 оны 412 дугаар тушаалын дагуу шинжээч томилох зарыг нийтэд түгээж 2 шинжээч томилсон. Одоогоор эрүүл	100%	100%	

			мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа.	мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх байгууллагад тусгай зөвшөөрөл олгох комисс 3 шинжээчтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.			
	7		8.6.10. мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл;	Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл байхгүй.	100%	100%	
	8		8.6.22. хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл. (8.6.Мэдээлэл хариуцагч энэ хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5-д зааснаас гадна өөрийн эрхлэх асуудлын хүрээний дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:)	Хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээллийг тухай бүр нь шилэн данс, байгууллагын вэб сайт, болон цахим орчинд байршуулж байна.	100%	100%	
УИХ-ын тогтоол							
4	9	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний	1.5.. Бүх шатны Засаг даргын үр дүнгийн гэрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс, сургалтын байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, тухайн	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс нь 2024 онд 10 удаа хуралдаж 77 хүүхэд орж, 17 хүүхэд асаргаанд шинээр хамрагдаж, 8 хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй болохыг шинээр тогтоож, 50- хүүхэд асаргаа сунгагдаж, 2 хүүхдийг онош баталгаажуулах шаардлагатай байгаа тул буцаасан. Сүхбаатар	100%	100%	

		тухай 2017-06-09 Дугаар 2017 №46	орон нутгийнхаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, сувилалд тэгш хамруулах асуудлыг тусгаж, үүрэгжүүлж ажиллах;	аймгийн Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах цахим сургалтад оролцсон. Жайка старт 2 төслийн багийн мониторинг, зөвлөн туслах үйл ажиллагаа явуулах баг Баруун-Урт сумын 4-р сургууль, 11-р цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцсан. Сургууль цэцэрлэгийн 80 багш, ажилтанд “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө”-өөр ажиллах, боловсролд хамрагдалтыг дэмжих багийн үйл ажиллагааг сайжруулах, тохируулгат хэрэглэгдэхүүн ашиглах, хүүхдийн хөгжлийг дэмжих танхим байгуулах, түүний ач холбогдол зэрэг мэдээллийг өгсөн. Мөн аймгийн боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол эрүүл мэнд нийгмийн хамгааллын салбар комиссын хурал, үйл ажиллагаатай танилцаж зөвлөгөө зөвлөмж өгч санал солилцсон. Хөгжлийн бэрхшээлтэй 115 хүүхэд Ерөнхий боловсролын сургуульд, 65 хүүхэд цэцэрлэгт, 27 хүүхэд насан туршийн суралцахуйн төвд суралцаж байна. Боловсролын байгууллагад хамрагдаж чадаагүй 27 хүүхэд байна.			
5	10	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2019-06-06	1.4/в/. аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудад нөхөн үржихүйн зөвлөгөө, мэдээллийг бүх хүнд хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, нөхөн үржихүйн кабинет, төрөх тасгуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээнд нийцүүлэн тохирох хэрэглэгдэхүүнээр хангах;	2024 онд “Эх хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний хүрээнд 6 зорилт, 28 арга хэмжээг төлөвлөсөн. Эх хүүхдэд ээлтэй байгууллага, орон нутаг болох хөдөлгөөнийг 05 сарын 01-д эхлүүлсэн. Жирэмсэн эхчүүдэд зориулсан жирэмсэн үед илрэх аюултай ерөнхий шинж, жирэмсний эрт хяналтын талаар видео шторкийг байрлуулан ард иргэдэд түгээж байна. 2024 оны эхний 5сарын байдлаар 448 эх төрсөн. Үүн дотор сонсголын бэрхшээлтэй 1 иргэн байсан ба дохионы хэлээр харилцан ярилцсан. Мөн АНЭ-ийн төрөх тасгийн давхар бүрд хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тэргэнцэр	70%	70%	

		Дугаар 2019 №62		байршуулсан. Мөн унаж хальтахаас сэргийлж хананд бариул тогтоосон.			
УИХ-ын байнгын хорооны тогтоол							
6	11	Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, хязгаарлах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2016-04-05 Дугаар 2016 №10 НББСШУБХ	3.1/. Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, ХДХВ/ДОХ-ын тархалтыг бууруулах, хязгаарлах тухай эрсдлийн удирдлагын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, (2018-2020 оны сүрьеэ, бэлгийн замын халдварт өвчний статистик ирүүлэх)	ЭМС-ын 2017 оны А/528 тоот тушаалын дагуу АНЭ, сумдын эрүүл мэндийн төвүүдийн 181 эмч эмнэлгийн мэргэжилтэнд халдварт өвчнөөс сэргийлэх хянах, илрүүлэх, эмчлэн эрүүлжүүлэх, тандалтын тогтолцоог сайжруулж халдварт өвчнийг бууруулах чиглэлээр танхимын сургалт зохион байгуулсан. ЭМС-ын хэмжээнд халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний 8 бүлэг 55 заалттай төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж байна. хэрэгжилт 85 хувь. 2024 оны эхний 05 сарын байдлаар 380 халдварт өвчин бүртгэгдсэн 10000 хүн амд 57.5 өмнөх оны мөн үеэс 27.9-өөр буурсан БЗДХӨ 56 бүртгэгдсэн нь 10000 хүн амд 8.5 өмнөх оны мөн үеэс 1.4 промиллиор буурсан байна. Сүрьеэ 23, 10000 хүн амд 3.5 өмнөх оноос 3.5-аар буурсан үзүүлэлттэй байна. 1. ЗХ-ны 338-р ангийн цэрэг, ажилтан албан хаагч зэрэг 233 хүнийг урьдчилан сэргийлэх хавьтлын үзлэг шинжилгээнд хамруулснаас шинэ халдвар илрээгүй, цээжний рентген зураг дээр илт өөрчлөлт үгүй, хуучин сүрьеэгээр өвчилж эдгэрсэн, өөрчлөлттэй 2 хүн байна. Эмнэлзүйгээр эмчилгээнд 2 хүн шинээр бүртгэн авав. 2. Цэргийн төв эмнэлгийн эмч нар Онгон, Наран, Дарьганга, Уулбаян, Мөнххаан, Халзан, Баяндэлгэр, Эрдэнэцагаан, Түвшинширээ сумдад ажиллаж нийт 2151 иргэнийг үзлэг шинжилгээнд хамруулсан. БЗДХӨ-ний шинжилгээнд - 1407 хуучин-50, сүрьеэ өвчнийг илрүүлэх үзлэг шинжилгээнд 2151 шинэ өвчлөл-0 байна 3. Явуулын	70%	70%	

				амбулаторийн тусламж үйлчилгээг эхний хагас жилийн байдлаар Онгон, Наран, Дарьганга, Түвшинширээ, Сүхбаатар, Түмэнцогт сумдад зохион байгуулсан. 18-49 насны 2329 иргэн хамруулсан шинэ халдвар- 4, Сүрьеэгийн үзлэг - 972 иргэн хамруулсан шинэ халдвар-2 тус тус илрүүлсэн байна 4.2024 оны эхний хагас жилийн байдлаар 5 төрлийн оношлуураар ЭМД-гүй 2764 (сахар- 912, холестерин-329, ХДХВ/ДОХ-760, Тэмбүү-860, хеликобактер-905) иргэнийг шинжилгээнд хамруулсан. Чихрийн шижингийн сэжигтэй тохиолдол-16, хеликобактерын сэжигтэй тохиолдол – 21 иргэнийг баталгаажуулах шинжилгээнд илгээж, эмчийн хяналтад авсан. ХДХВ/ДОХ-ын шинэ халдвар илрээгүй байна.			
7	12	Бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2016-12-14 Дугаар 2016 №04	2.1/. Хүн амын дунд БЗДХ-т өвчин нэмэгдэж байгаатай холбогдуулан аймаг, нийслэл, дүүргийн түвшинд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичигтээ ХДХВ ын халдвар, ДОХ болон БЗДХ-аас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгаж, хэрэгжилтийг хангах;	1. Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх арга хэмжээний 2024 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө"-г 8 зорилт 55 үйл ажиллагаа тусган ажилласан. Хэрэгжилт -70% . Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 05 сарын байдлаар 380 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 57,5 ногдож байна. Халдварт өвчнөөр өвчлөгсдийн тоо өнгөрсөн оны мөн үеэс 182 тохиолдлоор буурсан байна. Нийт бүртгэгдсэн халдварт өвчний БЗДХӨ 56/14.7%-ийг эзэлж байна Засгийн газрын мөрийн хөтөлбөр, Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хангах зорилгоор Эмнэлгийн тусламж үйлчилгээг “Явуулын хэлбэрээр үзүүлэх” тухай удирдамж батлуулан, Түвшинширээ, Дарьганга, Онгон, Наран, Сүхбаатар, Түмэнцогт сумдуудад үзлэг, ХДХВ/ДОХ/БЗДХ–ын шинжилгээг зохион байгуулан зорилтот бүлгийн нийт 7917 иргэн хамрагдахаас 2331/29%-тай хамрагдаж, шинэ 4 тэмбүү илрүүлэн,	70%	70%	

		НББСШУБХ		эмчилгээнд хамруулаад байна.			
	13		2.2/. Нутаг дэвсгэрийнхээ хүн амыг эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангахад шаардагдах зардлыг жил бүрийн төсөвтөө тусгаж батлуулах, зарцуулалтад хяналт тавих.	2024 онд эрүүл мэндийн салбар нь нийт 28,7 тэрбум төгрөгийн батлагдсан төсөвтэй ажиллаж байна. Үүнээс нийгмийн эрүүл мэндийн зардалд 103,6 сая төгрөг батлуулан зарцуулалтанд хяналт тавин ажиллаж байна.	100%	100%	
8	14	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2021-05-25 Дугаар 2021 №05 БСШУСБХ	1.9/. ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдалд мэргэжлийн хяналтийн байгууллагаар үнэлгээ хийлгэж, санал дүгнэлтийг улсын хэмжээнд нэгтгэн гаргаж, цаашид үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангах;	Хугацаа болоогүй	Х.Б	Х.Б	
Ерөнхийлөгчийн зарлиг							
9	15	Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай 2018-05-23	3.. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх	Эрүүл мэндийн газрын гадна талын хаягийг гэрэлтдэг Монгол бичгээр хийсэн. Ажилчдын ерөөний үүдний хаягыг Монгол бичгээр бичиж байршуулсан. Архив бичиг хэргийн ажилтан Монгол бичгийн цахим сургалтад хамрагдсан.	70%	70%	

		Дугаар 2018_46	ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай.				
10	16	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2019-05-30 Дугаар 2019_104	1.16.. Ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулиудын ойр орчмын түргэн хоолны болон түргэн үйлчилгээний цэгт хяналт тавих	Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын 2024 оны 10-00/27 тоот удирдамжийн дагуу Ерөнхий боловсролын сургуулийн орчинд худалдаалагдаж буй хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг Сүхбаатар сумын 4 аж ахуй нэгж байгууллагыг хамруулан, 4 дэлгүүрт 16 заалттай зөвлөмж хүргүүлэн ажилласан.	100%	100%	
11	17	Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай 2022-07-11 Дугаар 2022_159	2. Төрийн бүх байгууллага, Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газар, бүх шатны сургалтын байгууллагууд Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залсугай.	Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай ерөнхийлөгчийн зарлигийн дагуу Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залсан.	100%	100%	
ҮАБЗ-ийн зөвлөмж							
12	18	Хүнсний аюулгүй байдлыг хангах	3.10.. Хоол, хүнсний зөв, зохистой, соёлтой хэрэглээний талаарх сургалт, сурталчилгаа,	Хоол, хүнсний зөв, зохистой, соёлтой хэрэглээний талаарх сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд Эхийн сүүгээр хооллолт, нэмэгдэл	100%	100%	

14	20	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7	5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томъёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн	5.3. Байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтөлж байна. 5.4. Албан хаагчдын Монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээний хүрээнд сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг гарган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 5.5. Байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр бичсэн.	70%	70%	
----	----	--	--	--	-----	-----	--

			хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх.				
15	21	Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-09-14 Дугаар 2022_340	1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгах зорилгоор төрийн зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг сонгон шалгаруулалтын үндсэн дээр зохих хууль журмын дагуу хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус үүрэг болгосугай.	Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын иргэдэд үзүүлэх анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээг Энхлэн-Ачтан, Энэрэлт-Ачтан нөхөрлөлүүдтэй гэрээ байгуулан ажиллаж байна. Мөн хувийн эмнэлэгүүдтэй гэрээ байгуулан дотор, мэдрэл, шүдний нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг иргэдэд хүргэн ажиллаж байна. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй Түмэнцогт сумын ЭМТ-н шинэ барилга, Халзан сумын ЭМТ-н амбулаторын барилга, Онгон сумын ЭМТ-н барилгын их засварын ажлуудыг аймгийн худалдан авах ажиллагааны газар болон төрийн өмчийн бодлого зохицуулалтын газруудад тендер шалгаруулалт кохион байгуулж гүйцэтгэгч компаниудыг сонгон шалгаруулсан.	100%	100%	
16	22	Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-02-08 Дугаар 2023_55	1. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлийн явцтай уялдуулан төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын тухайн онд батлагдсан дүнд багтаан хөрөнгийн зохицуулалт хийж,	2024 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Түмэнцогт суманд баригдах 17 ортой эрүүл мэндийн төвийн шинэ барилгын гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендер шалгаруулалт төрийн худалдан авах ажиллагааны газар дээр зарлагдсан.	70%	70%	

			санхүүжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай				
17	23	Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн зарим арга хэмжээний тухай 2023-08-30 Дугаар 2023_321	2. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг харьяалах салбар, нутаг дэвсгэртээ зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, шаардагдах зардлыг төсвийн ерөнхийлөн захирагч нарын саналыг харгалзан улсын нэгдсэн төсвийн төсөлд тусган, хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхланд даалгасугай.	Монгол улсын Засгийн газрын 2023 оны □"Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх тухай" 321 дүгээр тогтоолын хүрээнд Эрүүл мэндийн сайд, Монгол улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд нарын 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/75/А09/А73/А34 дүгээр тушаалын дагуу Аймгийн Засаг даргын 2024 оны 351 дүгээр захирамжаар "Иргэний эрүүл мэндийн боловсролын дээшлүүлэх" арга хэмжээг зохион байгуулах зөвлөл байгуулагдсан. Тус зөвлөл 1 удаа хуралдаж, аймгийн хэмжээнд "Иргэний эрүүл мэндийн боловсролын дээшлүүлэх" арга хэмжээг зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргаж, холбогдох сум, агентлагт төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүрэг чиглэл өгч ажиллалаа.	70%	70%	
18	24	"Эрүүл шүд" арга хэмжээг хэрэгжүүлэх тухай 2023-08-30 Дугаар 2023_322	2. Сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон ерөнхий боловсролын сургуульд өдөр бүр "Шүд угаах цаг"-ийг бий болгон хэвшүүлж, эрүүл ахуйн шаардлага хангасан шүдээ угаах хэсэг бий болгох ажлыг үе шаттайгаар улс, орон нутгийн төсвийн болон гадаадын зээл тусламжийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр	ЗГ-ын 322 дугаар тогтоолын дагуу эрүүл ЭМС, БШУС-ын хамтарсан А/27, А/25 дугаар тушаалын дагуу БШУГ-тай хамтран эрүүл шүд арга хэмжээний 5 зорилт 25 заалттай төлөвлөгөө батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна. Эрүүл мэнд, боловсролын салбарт ажлын байранд шүдээ угааж хэвшицгээе цахим чөллэнж зарлаж 12 ЭМБ 15 ЕБС СӨБ - ын байгууллагууд хамрагдсан. Албан байгууллагуудаа урин идэвхижүүлж байна. ЭМГ-ын цахим хуудсанд 8 төрлийн мэдээ мэдээллийг байршуулан иргэдэд түгээсэн. хандалт - 5400 Амны хөндийн эрүүл ахуй сэдвээр 5 удаа танхимын	70%	70%	

			тусгаж, холбогдох арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	сургалт зохион байгуулж 200 хүүхэд хамрагдсан.			
19	25	Өвөлжилт, хаваржилтын байдал хүндэрсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2024-02-14 Дугаар 2024_62	2. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.4-т заасан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг гамшгаас хамгаалах алба, бүх шатны Засаг дарга, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад үүрэг болгосугай. (1.Өвөлжилт хүндэрсэнтэй холбогдуулан зудын эрсдэлийг бууруулах, хаваржилтын хүндрэлийг хохирол багатай даван туулах зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллагыг 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.)	ЭМС-ын 2024 оны А/89 дугаар тушаалын дагуу Өндөржүүлсэн бэлэн байдлыг хангах зорилгоор 13 сумын эрүүл мэндийн төвүүд отор нүүдлээр яваа иргэдийн судалгааг гарган 14 хоног тутам ЭМЯ-ны холбогдох мэргэжилтэнд 24 удаа хугацаанд нь хүргүүлэн ажилласан. Аймгийн хэмжээнд өвөлжилт хаваржилт, хүндэрсэнтэй холбоотой үерийн эрсдэлээс сэргийлэх, халиа тошин үүсэх, халдварт өвчнүүд нэмэгдэх, малчдын бие болон сэтгэл зүйн тулгамдсан асуудал үүсэх эрсдэлтэй болсон. Иймээс сэтгэл зүйн асуудалд дэмжлэг үзүүлэх зорилгоор сумдад Сэтгэцийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэгийг явуулж зөвөлгөө өгөх, үзлэг хийх удирдамж гарсны дагуу АНЭ-н сэтгэцийн эмч Түмэнцогт суманд 3 хоног ажилласан ба нийт 22 малчин өрхөөр орж сэтгэл зүйн зөвлөгөө өгч, 6 иргэнд сэтгэл засал эмчилгээ хийсэн. Төрийн байгууллагын 55 ажилтанд гамшгийн тухай ойлголт, гамшгийн үеийн сэтгэл зүйн хариу урвал, зөвөлгөө өгөх арга зүй стресс тайлах энгийн аргуудаар сургалт хийсэн. -ЭМЯ-аас 2 удаа нарийн мэргэжлийн эмч нарын баг томилогдож ажилласан. Эрүүл мэндийн байгууллагууд Юнител ХХК-тай гэрээ хийж алслагдсан болон отроор яваа малчин иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр 21000 иргэнд масс мессежийг хүргэсэн. Эрүүл мэндийн газраас 10 нэр төрлийн агуулгатай “Малчин таны гарын авлага”-г хэвлэн 12 сум, 2 өрхийн эрүүл мэндийн төвүүдээр	100%	100%	

				дамжуулан отроор яваа иргэд болон алслагдсан малчин иргэдэд 2500 ширхгийг олшруулан хүргэсэн.ЭМС-ын 2024 оны А/89 дугаар тушаалын дагуу Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбоотой ЭМГ, АНЭ, ӨЭМТ СЭМТ-үүдийн Гамшгийн төлөвлөгөөнд тодотгол хийж Онцгой байдлын газраар батлуулан ажиллаж байна.			
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл							
20	26	2022 оны 3 дугаар сарын 2-ны өдөр 14 дүгээр тэмдэглэл 2022-03-02 Дугаар 2022_14	ХИҮ.7.7. Нийлүүлэлт нь хүндэрч болзошгүй бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангахад шаардлагатай тээвэр, логистикийн зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Сүхбаатар аймгийн хэмжээнд 1,2 дугаар зэрэглэлийн 30 эмийн сан, 2 ЭХНБ-ллага үйл ажиллагаа явуулж байна. Тус байгууллагууд эм, эмнэлгийн хэрэгслийн тээвэрлэлтэд онцгой анхаарч , аюулгүй чанарын шаардлага хангасан эм, эмнэлгийн хэрэгслийг татан авч тасралтгүй бэлэн байдлыг ажиллаж байна. - Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодисын нөөц: 2024 оны 6 дугаар сарын байдлаар Эм тариа 24 нэр төрлийн - 468 сая төгрөг / 21-30 хоног/, Антибиотик 9-н нэр төрлийн -18,7 сая төгрөг / 14-21 хоног/, Вирусийн эсрэг эм, тариа 8 нэр төрлийн - 193 сая төгрөг /14-20 хоног/, Эмнэлгийн хэрэгсэл 12-н нэр төрлийн -19 сая төгрөг /14-21 хоног/, ХХХХэрэгсэл 10-н нэр төрлийн - 493 сая төгрөг / 21-30 хоног/, АХБодис 7-н нэр төрлийн - 22,4 сая төгрөг / 10-14 хоног/-ийн нөөцтэй байна	100%	100%	
21	27	2022 оны 6 дугаар сарын 15-ны өдөр 33 дугаар тэмдэглэл	ХIII.1. . Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, өнөөгийн нөхцөл байдлын талаар Хөдөлмөр,	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс нь 2024 оны хагас жилд 10 удаа хуралдаж 77 хүүхэд орж, 17 хүүхэд асаргаанд шинээр хамрагдаж, 8 хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй болохыг тогтоож, 50	100%	100%	

		2022-06-15 Дугаар 2022_33	нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахтай холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт даалгав: 1.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд болон салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хяналт тавих, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагааг зохих журмын дагуу дэмжиж ажиллах; 1.2. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн хуралдааны 34 дүгээр тэмдэглэлээр өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэх; 1.3. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн харилцаанд тэгш оролцох эрхийг хангах, хамгаалах хүрээнд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрхэлсэн салбар,	хүүхэд асаргаа сунгагдсан бол 2 хүүхдийг онош баталгаажуулах шаардлагатай байгаа тул буцаасан. Мөн ЭХЭМҮТ, УНТЭ, УХТЭ, ХБХСЗТ-тай хамтран хөгжлийн бэрхшээлтэй 27 хүүхдийг эрүүл мэндийн цогц үзлэг шинжилгээнд хамруулсан. Эрүүл мэндийн 16 байгуулагаар сэргээн засах эмчилгээнд давхардсан тоогоор хөгжлийн бэрхшээлтэй 420 хүүхдэд эмнэлгийн тусламж үлчилгээг үзүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 405 эцэг эх, асран хамгаалагчдад сургалт зохион байгуулж ажилласан.			
--	--	--------------------------------------	--	---	--	--	--

		харьяалах нутаг дэвсгэртээ хангуулж, хяналт тавьж ажиллах.				
	28	XIII.1.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх нийгмийн халамж, хөгжлийн үйлчилгээг сайжруулахтай холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт даалгав: 4.1. байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч, ажил хөдөлмөр эрхлээгүй байгаа эцэг, эсхүл эх, хууль ёсны асран хамгаалагчийн эрүүл мэндийн даатгалын болон тэтгэврийн даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож улсын төсвөөс төлөх боломжийг судлан саналаа шаардагдах зардлын тооцооллын хамт танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.2. Нийгмийн халамжийн сангаас олгож байгаа хөдөлмөрийн	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад хүүхдийн эрүүл мэндийн хөгжлийн эрт илрүүлэг үзлэгт 9,18,36 сартай 2584 хүүхэд хамрагдахаас 532 /20,6%/ хамрагдсан байна. Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссоор хөгжлийн бэрхшээлтэй 8 хүүхдийг шинээр тогтоож, асран хамгаалагч нарыг нь тэтгэмжид оруулсан. ХБХСЗТ-өөс зохион байгуулсан "Сайн туршлага-2024" арга хэмжээнд Сүхбаатар аймгаас эрүүл мэнд болон боловсролын салбараас 6 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон. Тус арга хэмжээнд тусгай хэрэгцээт хүүхэд суралцдаг 11 дүгээр цэцэрлэгийн бүтээл "Шилдэг оюуны бүтээл" номнацид шалгарсан. Эрүүл мэндийн байгууллагуудад дохионы хэлмэрчээр бэлтгэгдсэн 4 ажилтан байна. Бариад үсгээр богино хэмжээний сургалтад 1 ажилтанг хамруулсан. Бариад үсгийн цагаан толгойг цахим бүртгэлийн хэсэгт байршуулж, дуугүй хөтөчийг хэрэглэж байна. "Хүүхдийн аюулгүй байдал-Таны хариуцлагаас" аяны хүрээнд Эрүүл мэндийн газар , Орон нутгийн телевиз, Өрх, сумын эрүүл мэндийн төвүүдийн цахим хуудсаар дамжуулан эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдийн осол гэмтлийн эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх 49 мэдээ мэдээлэл, 22 төрлийн постер, 22 төрлийн зөвлөмж, 4 видеог 542 удаагийн давтамжтайгаар түгээсэн. Хандалт – 154520 , хуваалцах- 75, үзэлт-2560 хүнд мэдээлэл хүрсэн байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгууллагуудын "Шүхэр нэгдсэн бодлогын	100%	100%	

		чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр болон эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тэтгэмжийн хэмжээг 288,000 төгрөгөөр үргэлжлүүлэн олгох болон цаашид уг хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх боломжтой эсэхийг судалж, зохих арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа нарт; 4.3. хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд шаардлагатай хүний нөөцийн судалгааг хийж, дутагдалтай байгаа мэргэжилтнийг 2022-2023 оны хичээлийн жилээс эхлэн үе шаттайгаар бэлтгэх, сургалтын орчин, материаллаг баазыг бэхжүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт;	ерөнхий зөвлөл” ТББ-тай хамтран Сүхбаатар аймгийн төрийн байгууллагын албан хаагчид болон хөгжлийн бэрхшээлтэй нийт 50 иргэн, асран хамгаалагч нарт сургалт, хэлэлцүүлэгийг 1 удаа зохион байгуулсан. Эрүүл мэндийн байгууллагууд 7 удаагийн сургалтаар Хөгжлийн бэрхшээлтэй 69 иргэнд сургалт зохион байгуулж, 89 ширхэг гарын авлагыг асран хамгаалагч нарт түгээж, хөгжлийн бэрхшээлтэй 20 иргэнийг 560000 төгрөгийн витаминаар витаминжуулсан.			
--	--	--	---	--	--	--

		4.4. хөгжлийн бэрхшээлтэй хүнд эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлдэг эмнэлгийн мэргэжилтний урамшууллыг нэмэгдүүлэх асуудлыг судалж, шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэх талаар холбогдох арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.5. хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчийг хүүхдээ асрах, хөгжүүлэх, дэмжих чиглэлийн богино хугацааны сургалтад хамруулж, энэ чиглэлээр хөдөлмөр эрхлэх, цаашид мэргэжил эзэмшихэд нь холбогдох хууль тогтоомжийн дагуу дэмжлэг үзүүлж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.6. хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийг үнэлэх Үйлдлийн олон улсын ангилал (ICF)-ыг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн				
--	--	--	--	--	--	--

		сайд С.Энхболд нарт; 4.7. эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчгүй, байнгын асаргаа шаардлагатай сэтгэцийн хүнд хэлбэрийн эмгэгтэй, оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүний асрамжийн үйлчилгээ үзүүлдэг төрөлжсөн асрамжийн газрыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн дэргэд байгуулах асуудлыг судалж, шаардагдах санхүүжилтийг Монгол Улсын 2023 оны төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.8. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн эрүүл мэнд, сэргээн заслын цогц тусламж, үйлчилгээг өргөжүүлж, мэргэжил, арга зүй, хүний нөөц, эм хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжөөр хангах, үйл ажиллагааны чанар, үр дүнг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлэхийг Хөдөлмөр,				
--	--	---	--	--	--	--

			нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.9. харьяалах нутаг дэвсгэрийнхээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд эрүүл мэндийн болон нийгмийн сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлдэг, тэдний хөгжлийг дэмжих чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагааны болон санхүүгийн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт, 4.10. бага орлоготой, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, гэр бүлийн гишүүнтэй өрхийн орон сууцны хангамж, нөхцөлийг судлан сайжруулах шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.				
22	29	2022 оны 8 дугаар сарын 24-ний өдөр 42 дугаар тэмдэглэл 2022-08-24	ХҮ.3. . Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ,	2024 оны 5 сарын байдлаар Халдварт бус өвчний Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэг үзлэгт 7127/17%, Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт 6020/21.1 % , Умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгт 1182/25,6%, Хөхний эрт илрүүлэг үзлэгт	70%	70%	

		Дугаар 2022_42	оношилгоонд хамруулах үйл ажиллагааны явцын талаар Эрүүл мэндийн сайд С.Энхболд Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэхийг Эрүүл мэндийн сайд С.Энхболдод, уг үйл ажиллагаанд салбарын болон төрийн бүх шатны байгууллагуудын ажилтан, албан хаагчдыг хамруулах, энэ чиглэлд салбарын болон нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг уриалах ажлыг зохион байгуулж зохих арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав.	4367/33,3 % хамрагдсан байна.			
23	30	2023 оны 3 дугаар сарын 07-ний өдөр 11 дүгээр тэмдэглэл 2023-03-07	XII.2.1. Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдалтын явц, амны хөндийн эрүүл мэндийн өнөөгийн байдлын талаар Эрүүл мэндийн сайд	Хүн амыг эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг орон нутгийн түвшинд зохион байгуулж байна. 2024 оны 6 дугаар сарын байдлаар 18-с дээш насны эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 41565/11965 буюу 28.7 хувийн хамрагдалтай байна. Үзлэгт хамрагдсан иргэдийн дунд тэргүүлэх өвчлөл хоол боловсруулах	70%	70%	

		Дугаар 2023_11	С.Чинзориг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1.Хүн амыг эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэх, аймаг, нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа эрүүл мэндийг дэмжих төвүүдийг ходоодны уян дурангийн аппаратаар нэмэлтээр хангахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	эрхтэн тогтолцоо , дотоод шүүрлийн эмгэг мөн эмэгтэйчүүдийн дунд умайн хүзүүний үрэвсэл, үтрээний үрэвсэлт өвчнүүд тэргүүлж байна.			
24	31	2023 оны 5 дугаар сарын 17-ны өдөр 21 дүгээр тэмдэглэл 2023-05-17 Дугаар 2023_21	XVIII.2.3. Монгол Улсын хөгжлийн бодлого, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хүний хөгжил, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд эерэг үр нөлөөтэй байхад чиглүүлэн бодитой, үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.	Хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%	100%	
25	32	2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр 23 дугаар тэмдэглэл 2023-05-31	XXII.2.. “Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийн талаар Цахим	Шилэн дансны цахим хаягаар байгууллагын төсөв санхүү, хөрөнгө оруулалтын мэдээллийг тухай бүр байршуулсан. Мөн байгууллагын ил тод байдлын самбараар сар бүр мэдээллийг шинэчлэн байршуулсан. Нийт 80 мэдээлэл байршуулан ил тод нээлттэй мэдээлсэн.	100%	100%	

		Дугаар 2023_23	хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох мэдээлэл хариуцагч байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгов: 1.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллийг өөрийн байгууллагын цахим хуудаст, шаардлагатай мэдээллийг нэгдсэн систем (shilen.gov.mn)-д байршуулж, тухай бүр шинэчилж ажиллах; 2.Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-д мэдээллийг шууд холбох боломжтой байдлаар өөрийн байгууллагын системийн бэлэн байдлыг хангах; 3.Мэдээллийн сан, системийн хэвийн үйл ажиллагаа болон мэдээллийн үнэн зөв, алдаагүй байдлыг бүрэн хариуцах.				
26	33	2023 оны 10 дугаар сарын 04-ний өдөр 40 дүгээр	2.6. Ипотекийн зээлийг орон нутаг руу түлхүү чиглүүлэх, шилжин суурьшиж байгаа нарийн мэргэжлийн ажилтныг	2024 оны эхний хагас жилийн байдлаар нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн орон нутаг руу шилжин суурьшаагүй байна.	Х.Б	Х.Б	

		тэмдэглэл 2023-10-04 Дугаар 2023_40	орон сууцаар хангах асуудлыг судлан үзэж, арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, аймгийн Засаг дарга нарт;				
27	34	2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр 45 дугаар тэмдэглэл 2023-11-08 Дугаар 2023_45	XI.1.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй, хэрэгжээгүй зорилт, арга хэмжээний шалтгаан нөхцөлийг судалж, төлөвлөсөн хугацаа, үр дүнг тооцож, хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав;	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй, хэрэгжээгүй зорилт, арга хэмжээ байхгүй	100%	100%	
28	35	2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 51 дүгээр тэмдэглэл 2023-12-20 Дугаар 2023_51	XXV.4.3. Орон нутгийн иргэдийн эрт илрүүлэх үзлэгт хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав	2024 оны 4 дүгээр сарын 5-с Эрүүл сайдын тушаалын дагуу эрт илрүүлэг үзлэг шинжилгээг эрчимжүүлэх зорилгоор “Цэргийн төв эмнэлгийн” нарийн мэргэжлийн эмч нар сумдад үзлэг шинжилгээг хуваарийн дагуу амжилттай зохион байгуулан ажилласан.Нийт 9 суманд үзлэг шинжилгээг зохион байгуулж нийт 2151 иргэнийг үзлэг шинжилгээ, оношилгоонд хамруулсан. Мөнххаан суманд-240 • Уулбаян сум-242 • Түвшинширээ сум -120 - Баяндэлгэр сум-550 - Халзан сум-50 - Онгон сум-274 - Дарьганга сум- 199 - Наран сум - 195 - Эрдэнэцагаан сум - 281 иргэнийг хамруулсан. Иргэд дотор, гэмтэл, мэс засал, зүрх	100%	100%	

				судас, шүд, арьс харшил, нүд, мэдрэл, эмэгтэйчүүд, халдварт гэсэн 10 чиглэлээр үзлэгт орж, ХБДЗ-ын уян дуран, элэгний В,С вирус , ДОХ, Syphilis, ПАП тестийн шинжилгээ өгч оношлуулсан байна.Үзлэгт хамрагдсан иргэдийн дунд тэргүүлэх өвчлөл хоол боловсруулах эрхтэн тогтолцооны эмгэг, дотоод шүүрлийн эмгэг мөн эмэгтэйчүүдийн дунд умайн хүзүүний үрэвсэл , үтрээний үрэвсэл өндөр хувьтай гарсан. 18-с дээш насны иргэдийн хамрагдалт 41565/11965/28,7 хувьтай байна. Мөн 0-17 насны эрт илрүүлэгт хамрагдсан хүүхдүүдээс программд шивэгдээгүй хүүхдүүдийг VHS.HInfo.mn программд нөхөн шивэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. 6 сарын байдлаар нийт 601 хүүхэд программд шивэгдсэн байна.			
ЗГ-ын албан даалгавар							
29	36	“Шил” ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2023-04-17 Дугаар 2023_01	1.7. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах нээлттэй мэдээллийн ил тод болгож, тайланг хариуцсан салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд нэгтгэж хүргүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.	Шилэн дансны цахим хаягаар байгууллагын төсөв санхүү, хөрөнгө оруулалтын мэдээллийг тухай бүр байршуулсан. Мөн байгууллагын ил тод байдлын самбараар сар бүр мэдээллийг шинэчлэн байршуулсан. Нийт 80 мэдээлэл байршуулан ил тод нээлттэй мэдээлсэн.	100%	100%	